Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-д “хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол'' гэсэн заалтыг уг журамд нэмж тусгах.

Төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх нөхцлийг хангахад чиглэгдсэн зохицуулалтыг хуулинд нарийн тусгаж, мөрдөх.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид аливаа улс төрийн нөлөөллөөс ангид байж, албан тушаал ахих оновчтой зарчмийг баримтлах.

Төрийн алба улс төржихгүй байж, алс хэтийг харсан стратеги төлөвлөгөөг боловсруулан тууштай үргэлжлүүлэх, залгамж чанартай байх.

Иймд сонгон шалгаруулалтыг анхан шатны нэгжийн саналыг үндэслэн шинээр томилогдож байгаа бүрэлдэхүүнийг хуульд заасан шаардлагыг хангаж, анхан шатны нэгж дээр тухайн байгууллагын онцлогийг таниулж дадлагажуулах, томилогдсоны дараа ажлын байран дээрх давтан сургалтыг тогтмол явуулж байх шаардлагатай.

***С.Ганбат*** *-Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын ахмад*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АВРАГЧ, ГАЛ СӨНӨӨГЧДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛ

***Хураангуй.*** *Энэхүү нийтлэлээр онцгой байдлын албаны Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулах асуудлын талаар хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр*** *үг. Онцгой байдлын алба, аврагч, гал сөнөөгч, сэтгэл зүй, сэтгэл зүйн бэлтгэл*

Сүүлийн үед онцгой байдлын албаны алба аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь урт хугацаагаар ой, хээрийн түймэр болон малын гоц халдварт өвчин, цогцостой ажилллах дараах сэтгэл зүйн хангалтгүй байгаа зэрэг албан үүргээ биелүүлэхэд нь сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлүүдийг арилгаж чадах сэдэл төрүүлэх хэрэгтэй тул сэтгэл зүйн хангалт зайлшгүй чухал болох нь харагдаж байна. Иймээс тулгамдсан асуудлуудын нэг болох нийгмийн хамгааллыг сайжруулахгүйгээр бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг хангах нь учир дутагдалтай.

Онцгой байдлын газрын хүрээнд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 49 Гал унтраах, аврах анги. 21 эрэн хайх аврах анги, салбар бүлэгт 2196 ахлагч[1] бүрэлдэхүүн нь 18-38 хүртлэх насны залуучууд ажилдаг. Монгол Улсын ‘Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-т "Аврагчийг мэргэжлийн сургалтын төвөөр бэлтгэх, мэргэшүүлэх мөн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох", мөн Монгол Улсын шадар сайдын тушаалаар баталсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад алба хаах журам“-д “Албан хаагчдыг 3-5 жилд нэгээс доошгүй удаа албан тушаалынх нь чиглэлээр сургалтанд хамруулна” гэсэн байдаг. Энэ нь онцгой байдлын албаны бэлтгэл бэлэн байдлыг өндөр хэмжээнд байлгахыг шаардаж байна гэсэн үг.

***Аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй бэлтгэлд нөлөөлөх гэдэг нь*** хэрэгцээ шаардлага гарч тулгамдсан нөхцөл байдал үүссэн үед албан үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахдаа итгэл үнэмшилтэй, хууль эрх зүйн мэргэжлийн өндөр мэдлэгтэй, мэргэжлийн алдаа эндэлгүй чадварлаг ажиллаж. Гамшиг осол, цаг агаарын ямарч тохиолдолд оюун санаа болон өндөр ачааллыг давж чадах сэтгэцийн тоггвортой чанарыг бие бүрэлдэхүүнд төлөвшүүлэх тухай асуудал юм.

Өөрөөр хэлбэл төрөл мэргэжлийн аврагчдын албан үүрэг гүйцэтгэх явцад учирч болзошгүй аюул занал, бэрхшээл саадыг даван туулах тэдний сэтгэл зүй. ур чадварын нэг цогц үнэлгээ гэж ойлгож болно.

Сэтгэл зүйн хангалт нь “ Ёс суртахуун, сэтгэл зүйн онолын сургалт, сэтгэл зүйг бэлтгэлжилтээр тайван болон байлдааны цагийн ямарч нөхцөлд тавигдсан үүрэг зорилтыг биелүүлэхэд бие бүрэлдэхүүнийг төлөвгшүүлэх, тэдний тэдний ухамсарт зорилго чиглэлтэйгээр нөлөөлөх бүх шатнй захирагч, штаб албадуудын өвөрмөгч ажиллагаа мөн[2]”.

***Алба хаагчдын сэтгэлзүйн тогтвортой байдал гэдэг нь*** тэдний үүрэг, зорилтоо гүнзгий ухамсарласан ямар ч нөхцөлд өгөгдсөн үүрэг тушаалыг биелүүлэхэд бэлэн байх сэтгэлзүйн бэлтгэлтэй байхыг хэлдэг.

***Сэтгэл зүйн тогтвортой байдал:*** Доорхи хүчин зүйлүүдийг агуулж байдаг.

- Үүрэг даалгавраа гуйвалт, өөрчлөлтгүй биелүүлэх итгэл төгс байх;
- Ахуй хангалт амралт, хоол, хувцасны хангалт бүрэн хийгдсэн байх;

[1] Онцгой байдлын ерөнхий газрын дунд үеийн стратиге төлөвлөгөө 2015-2020

[2] *Г.Мягмаржав, С.Энхтайван.* Цэргийн сэтгэл судлалын практик асуудалууд - УБ„ 2009. 77дах тал.

- Удирдлага, хамт олны үйл ажиллагаанд итгэсэн байх зэрэг болно.

Сэтгэлзүйн хангалтыг дараах онолын үндэслэл, шалгуураар нягтлан зохион байгуулж ажиллах талаар анхаардаг. Үүнд:

1. Сэдлийн чадвар: Ажиллах чадвар, ажил хэрэгч чанар, санаачлагатай бүтээлч байдал;
2. Оюуны чадвар: Сэтгэн бодох чадвар, сэтгэхүйн хурд, ой ухааны хадгалах, санах чанар,;
3. Танин мэдэхүйн чадвар: Хүртэхүйн үйл ажиллагаа, төсөөлөн бодохуй, дүрслэн бодохуйн хэм хэмжээ анхаарлын төлөвлөрөлт сарнилтын байдал;
4. Сэтгэлийн хөдлөл: Сэтгэлийн догдлолоо илэрхийлэх байдал, аливаа эерэг, сөрөг цочроогчийг хүлээж авах мэдэрхүйн үйл ажиллагаа;
5. Зоригийн буюу сэтгэцийн тайлбартай шинж чанар: Зорьсондоо хүрэх шаргуу оролдлого, хүсэл тэмүүллийн үргэлжлэх хугацаа;
6. Бусадтай харьцах байдал, харилцан итгэлцэл, нийтэч чанар, амин хувиа хичээх байдал;
7. Авир араншин;
8. Шашин шүтлэг буюу итгэл үнэмшил зэрэг асуудлуудыг голлон анхаарч үздэг байна.

Аврагч, гал сөнөөгч бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг явуулахдаа нэн тэргүүнд түүнийг бүрдүүлэгч элементүүдийг тодорхойлж, бүрдэл хэсгүүдэд бүлэглэн авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Мэдрэхүйн болон сэтгэл санааны бэлэн байдал
2. Ёс суртахуун, итгэл үнэмшлийн төлөвшил
3. Аврах үйл ажиллагаанд сэтгэл зүйн хувьд бэлэн байх.

Сэтгэл судлалын ухааны арга зүйн үндэс нь ерөнхийдөө хүрээлэн буй бодит орчин ба сэтгэцийг ойлгох диалектик материалист хандлага, хүний сэтгэцийн хөгжил байгаль нийгмээс шалтгаалдаг тухай үзэл, онолын үндэс нь сэтгэц, уураг тархины үйл болох тухай төсөөлөл, сэтгэл зүйн шинжлэх ухааны арга зүйн тухай ойлголт зэрэг юм.

Орчин үед сэтгэлзүйн бэлтгэлийг авч үзэх ерөнхий хандлага үндсэндээ өөрчлөгдөөгүй бөгөөд ихэнх судлаачид үзэхдээ: "Сэтгэлзүйн бэлтгэл гэдэг нь сэтгэцийн функц ажиллагааны бололцоог дээшлүүлэх. орчин үеийн дайнд түүний хэвийн ажиллагааг хангах зорилго чиглэлтэй үйл ажиллагааг хэлнэ[1]" гэсэн байна.

[1] *Г.Мягмаржав, С.Энхтайван.* Цэргийн сэтгэл судлалын практик асуудал. - УБ,, 2009. 73 дахь тал.

Онцгой байдлын байгууллагын үндсэн үүрэг болох гамшиг ослоос урдчилан сэргиилэх. ард иргэдээ авран хамгаалах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах гол арга хэлбэр бол төрөл мэргэжлийн аврагч нарыг системтэй, шат дараалсан сургалтанд хамруулан сэтгэл зүйн байдлыг төлөвшүүлэх хамгын гол нь багаар ажиллах чадвар, дадлагат тулгуурлах явдал гэж үзэж байна. Гамшиг осол, гал түймрийн үед үүссэн цагийн байдал. байгаль цаг уур, газар нутгийн болон объектын онцлог, албан үүрэг гүйцэтгэхэд анги салаа, бүлгийн бүрдэл тэдний бие биеэнээ ойлгож хүндэтгэх байдал, мэргэжил мэдлэгийн төвшин, туршлага зэрэг олон хүчин зүйл нөлөөлнө.

Сэтгэлзүйн бэлтгэлийг зохион байгуулахад сэтгэлзүйн ухааны цэргийн сэтгэл судлал, цэргийн сурган хүмүүжүүлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан явуулах шаардлага байна.Аврагч, гал сөнөөгч нар үүрэг даалгаврыг салаа, бүлгээр гүйцэтгэх чадвартай байхын зэрэгцээ ганцаарчилан гүйцэтгэх чадварыг эзэмшсэн байх ёстой.

***М.Батмөнх*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын хошууч*

## ГАМШГААС ХАМГААЛАХ МЭДЛЭГИЙГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ОЛГОХ СУРГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

***Хураангуй.*** *Гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын уламжлал шинэчлэл, эрх зүйн зохицуулалтын талаар холбогдох бүтээл, эрх зүйн баргшт бичгийг судлаж дүн шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд гамшгаас хамгаалах мэдлэгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох сургалтын эрх зүйн орчинг сайжруулах ямар боломж байж болох саналуудыг дэвшүүллээ.*

***Түлхүүр*** *үг. Хөгжлийн бэрхшээл, эрх зүй, гамшгаас хамгаалах*

Монгол Улсад сүүлийн 15 жилд тохиолдсон гамшгийн нөхцөл байдлын статистикаас харахад жилд дунджаар 2900 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 200 орчим хүн амь насаа алдаж, 100 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 16.0 хувь нь зам тээврийн осол, ахуйн осол, үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй болсон байна[1].

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг олон нийтийн хүч, оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх үзэл санаа дэлхий нийтэд, ялангуяа уур

[1] Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхтгэл. - УБ., 2015. 2 дахь тал.